

**ӨВӨР МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГТ
ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭЗЛЭХ БАЙР,
ХӨГЖЛИЙН ТҮВШИН, ХУРДАЦ,
САЛБАРЫН БОЛОН НИЙГМИЙН
БҮТЭЦ**

Ц. Баатар

ХКН-ын XIII их хурлаас хойшхи хугацаанд үндэсний өөртөө засах орнуудын эдийн засаг, санхүүгийн талаар биеэ даасан байдлыг хангах эрх мэдлийг нь улам өргөтгөх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, үйлдвэрлэх хүчийг нэмэгдүүлж, эдийн засгийн салбаруудын харилцаа холбоо, бие биеэ шүтэлцэх арга зам, эмчийн янз бүрийн хэлбэрүүдийг өргөн ашиглах талаар онцгой анхаарч байна. Аж ахуйг оновчтой эрхлэн хөтлөх арга, удирдлага, зохион байгуулалтын бүтцийг улам боловсронгуй болгох чиглэлээр нам төрөөс авч явуулсан олон талт арга хэмжээнүүд үндэсний өөртөө засах муж орнуудын нийгэм эдийн засгийн амьдралд бодитой хэрэгжиж мэдэгдэхүйц ахиц өөрчлөлт гарсаар байна. Үүнийг Өвөр Монголын Өөртөө засах орны улс ардын аж ахуйн үндсэн салбар болох хөдөө аж ахуйн жишээн дээр авч үзье.

1. Өвөр Монголын эдийн засагт хөдөө аж ахуйн эзлэх байр

Өвөр Монголын хөдөө аж ахуй энэ Өөртөө Засах орны төдийгүй Хятад улсын хэмжээнд ч нэн их ач холбогдолтой салбар юм. Хятад улсад явагдаж буй аж ахуйн системийн шинэчлэлийн хүрээнд Өвөр Монголын эдийн засаг, аж ахуйн онцлогийг харгалзан мал аж ахуй, ойн үйлдвэрлэлийг гол салбар болгон эрчимтэй хөгжүүлж, аж ахуйн бусад салбарыг зохистой хослуулах үндсэн чиглэл тогтоов. ХАА-н үйлдвэрлэлийн харилцааны томоохон хэлбэр болж байсан ардын коммуныг энэ салбарын хөгжилд чөдөр тушаа болж байна гэсэн дүгнэлт хийж, зоригтой өөрчлөн коммуныг хэрэг дээрээ бүрмөсөн тарааж, хөдөө аж ахуйг гэр бүлийн хувийн жижиг аж ахуйн хэлбэрт ойртуулж, аж ахуйг эрхлэн хөтлөх гэрээ түрээсийн янз бүрийн хэлбэрийг туршин хэрэгжүүлсний үр дүнд сүүлийн 10 орчим жилд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд мэдэгдэхүйц ахиц өөрчлөлт гарч гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ тогтвортой нэмэгдэж ирэв.

8. Документы XIII всекитайского съезда КПК. Пекин., 1988, с. 34—35

9. Жэньминь жибао. 1988. IV. 16

10. Уз: Проблемы Дальнего Востока, 1987., No 2 с. 8 Жэньминь жибао. 1986. XII 3.

11. Ляован. 1988, № 15, х 1

12. Жэньминь жибао, 1979, VII. 9

13. КНР. Конституция и законодательные акты. М., 1984, с. 229-232; 253—255.

14. Жэньминь жибао, 1981. XII, 17

15. КНР в 1986 году: Политика, экономика, культура., М., 1988 г. с. 16

16. Современное право КНР., М., 1985., с. 130-133

17. Ляован, 1988, № 15, х, 6

18. Гуанмин жибао, 1988. IV. 16.

19. Гуанмин жибао, 1988. III. 2.

Хятад улсад одоогийн мөрдөж байгаа аргачиллаар бодоход Өвөр Монголын үндэсний орлогод хөдөө аж ахуй барагцаалбал 40 орчим хувийг эзэлж байна. Хөдөө аж ахуй хөгжүүлэхийн зэрэгцээ энэ Өөртөө Засах оронд үйлдвэржүүлэх бодлого явуулж ирсэний үр дүнд эдийн засгийн бүтцэд ихээхэн өөрчлөлт гарлаа. Аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувийн жинг статистикийн мэдээ, судалгааны бусад материалд¹ үндэслэн 1988 оны байдлаар барагцаалан гаргавал аж үйлдвэрийнх 60 хувь, хөдөө аж ахуйнх 40 орчим хувийг тус тус эзэлж байна.

Өвөр Монголын аж үйлдвэрийн үндсэн чиглэл нь хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулах явдал юм. Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг аж үйлдвэрт боловсруулж экспортын болон дотоодын хэрэгцээг хангах болсон учраас хөдөө аж ахуйн гол нэг зорилт бол аж үйлдвэрийн салбарын улам бүр өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахад чиглэжээ.

Хөдөө аж ахуй Өвөр Монголын гадаад худалдаанд чухал байр суурь эзэлж байна. 1986 оны байдлаар хөдөө аж ахуйн 243 нэр төрлийн бүтээгдэхүүн (хөдөө аж ахуйн гаралтай аж үйлдвэрийн бүтээг дэхүүнийг оролцуулаад) экспортод гаргаж байв.² Үүний зонхилох хэсэг нь цэвэр ноолуур, ээрүүлийн ноолууран утас, ноолууран цамц, хивс, өлөн гэдэс, гахайн зогдор, адууны хялгас, нэхий, нэхий дээл үхэр, хонь (амьдаар), үхэр, хонь, тэжээвэр туулайн хөлдөөсөн мах, ёотон, цэвэр ноос, ноосон болон хольцтой цэмбэ, түүнчлэн зээргэнэ, чихэр өвс, түүний ханд, хунчир зэрэг дэлхийн зах зээлд эрэлт ихтэй бүтээгдэхүүнийг 60 гаруй оронд гаргаж байна.

Өвөр Монголын хөдөө аж ахуй хүн амын хүнсний хангамжид онцгой байр эзэлнэ. Энэ нь нэг талаас тус Өөртөө Засах орны хүн амын механик өсөлт түргэн ихэссэн, нөгөө талаас ард түмний аж амьдрал дээшилж, худалдан авах чадвар нь өсөн нэмэгдэж байгаагаар тайлбарлагдана. Ер нь Хятадын хэрэглээний фондын ихээхэн хэсгийг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн эзэлж байна.

Урьд Өвөр Монголын хүн амын олонхи нь хөдөөд сууж, хөдөө аж ахуйг шүтэж амьдардаг байсан бол одоо нийт хүн амын 56,5 орчим хувь нь хөдөөд сууж, материаллаг үйлдвэрлэлд ажиллагсдын 50 гаруй хувь нь хөдөө аж ахуй эрхэлж байна гэж барагцаалан тооцоолж болох юм. Үүнээс зөвхөн газар тариалангийн салбарт 11167 мянга буюу нийт хүн амын 55,6 хувь нь ажиллаж байна³.

Хэдийгээр нийгмийн нийт бүтээгдэхүүн болон ХАА-д ажиллах хүн амын эзлэх хувийн жин ийнхүү буурч байгаа боловч энэ нь уг салбарын ач холбогдол буурч байгаа хэрэг огт биш юм. Харин аж үйлдвэр болон хүн амын хэрэгцээ улам өсөн нэмэгдэж байгаа тул хөдөө аж ахуй улам их ач холбогдолтой болж байгаа юм. Тийм ч учраас Өвөр Монголд хөдөө аж ахуй ялангуяа мал аж ахуйг гол болгон хөгжүүлэх үндсэн чиглэл тогтоож өргөн далайцтай арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлж байна.

II. Хөдөө аж ахуйн хөгжлийн түвшин, хурдац

Өвөр Монголын хөгжлийн түвшинг мэдэхийн тулд юуны урьд Хятад улсын бусад муж, өөртөө засах орнуудтай харьцуулан үзэх нь зүйтэй.

1983 оны байдлаар Өвөр Монголын улс ардын аж ахуйн нийт бүтээгдэхүүний 40,7 хувийг хөдөө аж ахуйн салбар гаргаж байв. Үүнийг Хятадын хэмжээнд авч үзвэл 12-р байранд байгаа ажээ. Хөнгөн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээгээр улсдаа 20, хүнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр 14-р байранд тус тус

орж байлаа. Мөн хугацаанд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр өөртөө засах орнуудаас Төвд тэргүүн байранд, Шинжаан 9-р байранд, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүнээр Шинжаан 18, Өвөр Монгол 20, Төвд 26, хүнд үйлдвэрээр Өвөр Монгол 14, Шинжаан 16, Төвд 29-р байранд тус тус орж байжээ⁴.

БНХАУ-ын шинэчлэн найруулсан үндсэн хууль, нам төрийн бусад баримт бичигт үндэсний цөөнх оршин суудаг муж, өөртөө засах орнуудын нийгэм-эдийн засгийн хөгжлийг хурдасгах, хөгжлийн түвшинг ойртуулахад зориулж улсаас эдийн засаг, санхүүгийн болон материал-техникийн тусламж үзүүлэх талаар тодорхой заасны дагуу зохих арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Ингэснээр дээрхи үзүүлэлтүүдэд ч өөрчлөлт гарах болов. Тухайлбал, 1988 онд Өвөр Монголын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 26 млрд. 79 сая юань, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлбэр нь 20 млрд. 649 сая юань байв⁵. Дээрх тоо баримтыг үндэслэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг тооцоолж үзэхэд 7 млрд. орчим буюу , аж үйлдвэр, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 35 хувийг эзэлж байна.

Хөгжлийн түвшинг зэрэгцүүлж үзэх нэг гол үзүүлэлт бол хүн тутамд дунджаар ноогдож байгаа бүтээгдэхүүн юм. Өвөр Монголд үйлдвэрлэсэн хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүнийг хүн амд нь хувааж үзвэл олон үзүүлэлтээр дэлхийн түвшнээс доогуур байна. Тухайлбал, мах 11,49 жин (1 жин = 500 гр.), сүү 14,57 жин, ноос, ноолуур 5,38 жин байна.

Аливаа нийгэмд хөгжлийн түвшинг харуулах гол хэмжүүр бол эцсийн бүлэгт хөдөлмөрийн бүтээмж байдаг. Өвөр Монголын хөдөө аж ахуйн хөдөлмөрийн бүтээмж урьд өмнөхийг бодвол дээшилж байна.

Хятадын хэвлэлд гарсан тоо баримтыг үндэслэн Өвөр Монголын хөдөө аж ахуйн хөдөлмөрийн бүтээмжийг 1988 оны байдлаар ойролцоогоор тооцоолон гаргаж үзвэл 636,4 юань болж байна. Энэ нь хөдөө аж ахуйд хөдөлмөр эрхэлж байгаа нэг хүний тухайн жилийн хөдөлмөрийн бүтээмж ямар байгааг харуулах баримт юм. Тодруулж хэлбэл, хөдөөд аж ахуй эрхлэн хөтлөх гэрээ, түрээсийн янз бүрийн хэлбэр бий болж өмчийн харилцаанд өөрчлөлт гарч өрх гэрээрээ биеэ даан үйлдвэрлэл явуулж, гарах бүх зардлаа өөрснөө хариуцдаг болсон аж ахуйн шинэчлэлийн өнөөгийн нөхцөлд өрхийн хөдөлмөрийн чадвартай нэг хүн улсад жилд дунджаар 636,4 юаний бүтээгдэхүүн үйлдвэрлэн өгч (худалдаж—Ц.Б.) байна гэж ойлгож болох юм. Улсад ийм хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн тариачид, малчдын жилийн дундаж орлого 1988 оны байдлаар 547,15 юань, Хятад улсын хэмжээнд тариачдын дундаж орлого 545 юань байгаагаас арай илүү аж.⁶ Үүнээс үзвэл хөдөө аж ахуйн хөдөлмөрийн бүтээмж харьцангуй доогуур байгаа нь харагдаж байна.

Өвөр Монголд үйлдвэрлэж байгаа хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн, хөдөлмөрийн бүтээмж, чанарын зарим үзүүлэлтээр дэлхийн дунджаас хоцорч яваа үндсэн шалтгаан гэвэл: Нэгд, нийгэм-эдийн засгийн хөгжлийн өвөрмөц онцлогтой холбоотой. Хоёрт, байгаль, цаг уурын нөхцөл Хятадын бусад муж, өөртөө засах орнуудаас онцгой өвөрмөц, хатуу ширүүн байгаа нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, түүний түвшинд багагүй нөлөө үзүүлж байгаа юм. Унаж байгаа тунадас, ургамлын ургах хугацаа, агаарын температур, хөрсний шим тэжээлээр харилцан адилгүй. Гуравт, тухайн үед хөдөө аж ахуйн талаар явуулсан төрийн буруу ташаа бодлого зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байгаа юм.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжилд нөлөөлж буй дээрх шалтгаан нөхцөл, сөрөг нөлөөллүүдийг багасгах чиглэлээр сүүлийн

жилүүдэд олон чухал арга хэмжээ авлаа. Жишээлбэл энэ салбарын материаллаг баазыг бэхжүүлэхийн тулд хөрөнгө гаргаж цахилгаан жуулах, механикжуулах ажлыг эрч далайцтай хийж байна. Сүүлийн хэдэн жилд 4500 орчим услалтын систем байгуулж, 11 мянган өрөмд мөл худаг гаргаж, 933 мянган га талбайг усжуулж, 1,73 сая га хадлангийн талбайг хашиж хамгаалсан байна⁷. Түүнчлэн 3600 гаруй хашаа хороо барьж, малын тэжээл үйлдвэрлэх 20 үйлдвэр, 5000 орчим бага оврын цех байгуулжээ.⁸ Хөдөө аж ахуйн салбарын эрчим хүч 6,4 17 сая морины хүчинд хүрчээ. Олон ажил гүйцэтгэх бага оврын трактор 118 мянга, автомашин 8497 ажиллаж байна. Газар тариалангийн үйлдвэрлэлд жилд дундчаар 199 мянган тонн химийн бордоо хэрэглэж буй аж.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн харилцаа, удирдлага, зохион байгуулалтад хийсэн өөрчлөлт шинэчлэлт, энэ чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа олон талт арга хэмжээний үр дүнд хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ тасралтгүй нэмэгдэж, эдийн засгийн үр ашгийн үзүүлэлтүүд өсч, түүний хөгжлийн түвшинд мэдэгдэхүйц ахиц гарч байна.

II. Хөдөө аж ахуйн салбарын бүтэц

Өвөр Монголын хөдөө аж ахуй, мал аж ахуй, газар тариалан гэсэн үндсэн хоёр салбартай. Энэ нь дотроо хэд хэдэн хэсэгт хуваагдана. Үүнд:

1. Малжих орон (тэдний нэрлэдэгээр) буюу мал аж ахуй дагнан эрхэлсэн;
2. Тариалах орон — газар тариалан дагнан эрхэлсэн;
3. Мал аж ахуй, газар тариалан хослон эрхэлсэн;
4. Газар тариалан, мал аж ахуй хослон эрхэлсэн;
5. Хотын дүүргийн мал аж ахуй эрхэлсэн;
6. Хотын дүүргийн газар тариалан эрхэлсэн аж ахуйнууд гэсэн хэсгүүдээс бүрдэл болно.

Өвөр монголчууд бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг. Газар нутгийнх нь 75 хувь буюу 88 сая га бэлчээрийн талбайтай. Үүнээс 66,6 сая га-г шиглаж байна.

1988 оны эцсээр 36,3 сая малтай байв.⁹ Өвөр Монголд бэлчээрийн мал аж ахуй дагнан эрхэлдэг 24 хошуу байна. Тэдний газар нутаг нь Өвөр Монголын бүх нутаг дэвсгэрийн 59,23 хувийг эзлэнэ.¹⁰

Өвөр Монголын бог, бод малын 46,6 хувь нь дээрх хошуудад байна. Өөртөө засах орны үхэр, хонины мах бэлтгэлийн 45-56 хувь, ноосны 40 хувийг тус тус бэлтгэж нийлүүлнэ¹¹.

Хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 29,6 хувийг мал аж ахуйн салбар үйлдвэрлэнэ. Хөдөө аж ахуйд ажиллагсадын 20 орчим хувь буюу ойролцоогоор 545 мянган хүн мал маллаж байна. Түүний 90 хувь нь Өвөр Монголын уугуул хүн ам болох малчин монголчууд юм.

Мал аж ахуй дотроо таван хошуу малаас гадна гахай, туулай, илжиг, луус, төрөл бүрийн шувуу зэрэг салбараас бүрдэнэ. Мал аж ахуйн бүтээгдэхүүний ихэнхийг хонь, үхрийн аж ахуй өгч байна. Зөвхөн хонь гэхэд л Өвөр Монголын малын тоо толгойн 47 хувийг эзлэнэ. Хонины тоо толгой адууныхаас 15 дахин, үхрийнхээс 6 дахин их байна.¹² Тийм учраас хонины аж ахуйн таваарлаг чанарыг дээшлүүлэх талаар их анхаарал тавьдаг. Жишээлбэл Жирэм аймгийн 8 хошууны хонь өөртөө засах орны бүх аймгийн хонины 24,1 хувийг эзэлдэг боловч ноосны 41,7 хувийг бэлтгэдэг байна. Учир нь энэ аймаг нийт хонины 70 хувийг үүлдэр сайжруулсан байна.¹³

Мал аж ахуйн салбарын тулгамдсан асуудал гэвэл энд юуны өмнө бэлчээр орно, Бэлчээрийн мал аж ахуйн гол шүтээн-нутаг бэлчээрт зүй бусаар хандасны уршгаар бэлчээр их хэмжээгээр хорогдож муудсан учир мал-бэлчээрийн зохистой харьцаа ихээхэн алдагджээ. Тухайлбал, Өвөр Монголын судлаачдын үзэж байгаагаар өнөөгийн байдлаар 23,4 сая мал (хонин толгойд шилжүүлснээр) бэлчээрийн даацаас илүү байгаа ажээ.¹³ Ийм байдал мал аж ахуйн ашиг шим чанарын үзүүлэлтэд ихээхэн нөлөөлж байгаа юм. Энэ гашуун сургамж, бий болсон байдлыг ул суурьтай авч үзээд тодорхой арга хэмжээ авч эхэлсэн юм. Тухайлбал, Өвөр Монголд ой мод, мал аж ахуй» дагнан хөгжүүлэх гол чиглэл тогтоож, 1985 онд бэлчээр ашиглах, хамгаалах хууль гаргаж, бэлчээр хагалахыг хориглож, төрийн хяналтыг хүчтэй болгов. Бэлчээр зөв зохистой ашиглах систем боловсруулж, түүнийг аажим аажмаар шатлан нэвтрүүлж байна. Элсжиж муудсан бэлчээрийг сэргээж олон наст ургамал тариалах, ойн зурвас байгуулах, хөрсний эвдрэл зогсоох чиглэлээр их ажил хийж, мэдэгдэхүйц амжилт олж бэлчээрийн талбайг өргөтгөж байна. Жишээлбэл, 1987 оны байдлаар нэг тэрбум 700 сая му бэлчээрт олон наст ургамлын үр тариалж өвс ургамал сайтай малын бэлчээр болгожээ. Өвөр Монголд өнөөгийн байдлаар 5,3 сая га буюу нутаг дэвсгэрийн 23,72 хувьд нь газар тариалангийн үйлдвэрлэл явуулж байна. Энэ салбар хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 70,4 хувийг үйлдвэрлэх бөгөөд ажиллагсадын 80 орчим хувь нь ажиллана. Хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалт, үндсэн хөрөнгийн ихэнх нь энэ салбарт хамрагдана.

Газар тариаланд үр тариа зонхилох суурь эзлэнэ. Үр тариа газар тариалангийн бүтээгдэхүүний барагцаалбал 80 орчим хувийг өгч байна. 1988 онд газар тариалангийн салбар 7383 мянган тонн үр тариа, 567 мянган тонн ургамлын тос, 219 мянган тонн чихрийн лууван үйлдвэрлэжээ.¹⁵ Түүнчлэн төрөл бүрийн хүнсний ногоо, тослог ургамал тариалах явдалд их ач холбогдол өгдөг. Өвөр Монголд чихрийн лууван, шар буурцаг, шиш будаа, шар будаа, эрдэнэ шиш голчлон тариална. Сүүлийн үед техникийн болон малын тэжээлийн ургамал эрчимтэй тариалах болов.

Түүнчлэн модыг үрээр болон шилжүүлэн суулгах, таримал ой, ойн зурвас байгуулах ажил далайцтай өрнөж байна. Өвөр Монголд жил бүр 10 мянган хүн гаргаж ойжуулах ажлыг зохион байгуулалттай хийж ирэв. Зөвхөн 1982—1987 онд 2600 мянган му талбайг ойжуулжээ.

Газар тариалангийн салбарт нэмж газар хагалахгүйгээр га-гаас авах ургацыг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлж шинжлэх ухаан техникийн ололтыг өргөн нэвтрүүлж байна.

Хөдөө аж ахуйд мал аж ахуй газар тариалангаас гадна ой мод, загасны аж ахуй болон туслах үйлдвэрлэлийн салбар чухал байр суурь эзлэнэ. Тухайлбал, хөдөө аж ахуйн барилга, усжуулалт, тээвэр болон хөдөөгийн хүн амын өргөн хэрэглээний үйлдвэрлэлийн тэргүүлэх хурдацыг хангахад чиглэсэн дэд бүтцийн төрөлжсөн хэлбэр, үйлчилгээний янз бүрийн хүрээ ихээхэн өргөжиж байна. Авч хэрэг жүүлж буй дээрх арга хэмжээнүүд нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбар хоорондын зохистой харьцаа бий болгож, эдийн засгийн үзүүлэлтүүдийг дээшлүүлэх гол хөшүүрэг болж байна.

IV. Хөдөө аж ахуйн нийгмийн бүтэц

Хөдөө нутагт явуулсан аж ахуйн механизмын өөрчлөлттэй уялдан 80-аад оноос Өвөр Монголын хөдөө аж ахуйн нийгмийн бүтцэд

ихээхэн өөрчлөлт гарлаа. Коммун, их бригад гэх зэрэг хөдөө аж ахуйн хамтын хэлбэрийг өөрчилж түүнийг жижиг өрх гэрийн хувийн аж ахуйн хамтын хэлбэрийг өөрчилж түүнийг жижиг өрх гэрийн хувийн аж ахуйн хэлбэрт ойртуулж, аж ахуйг эрхлэн хөтлөх гэрээ, түрээсийн янз бүрийн хэлбэрийг хэрэгжүүлсэн юм. Аж ахуйн механизмын энэ шинэчлэл нь хөдөө аж ахуйн салбар дахь үйлдвэрлэлийн харилцааны бүхий л элементүүдийг малчид, тариаланчдад тараан өгч түүнд амины өмчтэй адил харьцаж аль аль талдаа ашигтай, үр өгөөжтэй ашиглах эдийн засаг, зохион байгуулалтын таатай нөхцөлийг бүрэлдүүлжээ.

Өвөр Монголын Хөдөө аж ахуйд газар тариалангийн салбарыг гол болгож бусад туслах аж ахуйн чанартай үйлдвэрлэл явуулдаг 66 хошуу, мал аж ахуй дагнасан 24 хошуу байна. Хөдөө аж ахуйд үндсэн үйлдвэрлэл явуулах өрх, дагнасан өрх, хадлан тэжээл бэлтгэх өрх, үйлчлэх өрх, ханган борлуулах өрх, сүү сааль боловсруулах ажлын тусгай өрх, тариачид, малчдын хэрэгцээнээс илүү гарсан үр тариа, мал зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг худалдан борлуулж зуучлах өрх, ахуйн үйлчилгээ хариуцсан өрх, хөдөө аж ахуйн техникээр үйлчлэх өрх зэрэг үйлдвэрлэлийн анхан шатны нэгжүүд ихээхэн өргөжиж байна.

Хөдөө аж ахуйн нийгмийн бүтцийн өөрчлөлтийг мал аж ахуйн салбараар жишээ болгон тодруулан авч үзье. Энэ салбарт хэрэгжүүлж буй «мал, бэлчээрийн хос даачлалтын» дүрэм, өөрөөр хэлбэл, мал бэлчээрийг малчин дааж авах буюу хариуцан авах дүрэм ёсоор малд үнэ ханш тогтоон 10—15 жилийн дотор үнийг төлөөд малаа өөрийн болгох нэг хэлбэр, малыг үнэлэхгүйгээр тодорхой тооны малыг хариуцуулан өгч 5—10 жилийн дараа уг малаа анхны өгсөн тоогоор эргүүлж авахаар малчдад гэрээгээр маллуулах ийм хоёр хэлбэр зонхилж байна. Малыг үнэлэх буюу хугацаа тогтоож маллуулаад эргүүлэн авахаар малчин өрхөд тарааж өгөхдөө малтай амин судасны холбоо бүхий үйлдвэрлэлийн онцгой хэрэгсэл болох бэлчээрийг малаас салангид ойлгож ирсэн өнгөрсөн үеийн хатуу сургамжийг санаж, мал бэлчээрийг нэг зүйлийн хоёр тал болгон авч үзээд бэлчээрийг хамтад нь хариуцуулж ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг тодорхой болгосон нь хариуцлагын дүрмийн нэг онцлог тал юм. Бэлчээрийг зүй бус ашиглаж, даацаас хэтэрсэн мал өсгөж бэлчээр талхалж сүйтгэсэн малчин өрх хуулиар хариуцлага хүлээнэ. Ийм учраас малчин малаа өсгөө гэвэл хариуцсан бэлчээрээ зохистой ашиглаж, арчлан тордож, элсжиж муудсан газар нутагт олон наст ургамал тариалах замаар бэлчээрээ өргөтгөдөг байна. Жил бүр тогтоосон хувь хэмжээний дагуу ус бэлчээр хэрэглэсний албан татварыг улсад тогтмол төлж байх үүрэгтэй.

Өвөр Монголын мал аж ахуйд хэрэгжүүлсэн хариуцлагын дүрмээ мал, мал аж ахуйд үйлдвэрлэлийн хэрэгслийг малчдад хугацаа тогтоон үнэлэн худалдсанаар хошуу сумаас улаан мөнгө зарцуулаагүй байж мал, мах, сүү, тос, ноос зэрэг бүтээгдэхүүн нийлүүлэх улсын даалгаврыг зовох юмгүй биелүүлж байна. Мал аж ахуйн үйлдвэрлэл явуулахад хөрөнгө оруулах, малчдын цалин олгох зэрэг элдэв зүйлд зардал гаргахгүй. Түүгээр ч барахгүй хошуу сумын төсөв нь ус бэлчээр хэрэглэсний болон мал аж ахуйн албан татвараар байнга арвижиж байна.

Тэгвэл энэ бүхнээс малчдад гарах ашиг юу байна вэ? Хариуцлагын дүрмээр мал, бэлчээрийг малчинд нь баталгаатайгаар эргүүлэн холбосон явдал малчдын хувьд юугаар ч сольшгүй сонирхол төрүүлж чин хүслэн нь биелэв. «Нийгмийн», «нийтийн» гэсэн ойлголт нь ч арилав. Мал бэлчээрийг улсын өмнө хариуцан авсан малчин,

улс хоёрын хооронд шинэ маягийн харилцаа үүссэнээр хөдөлмөрийн бүтээмж, үйлдвэрлэлийн хэмжээ эрс нэмэгджээ. Малчид урьдынхаас их ажилладаг болж, ажил нь чих болжээ. Гэхдээ тэд тэр хэрээр их ашиг орлого олж байна. Хамгийн гол нь малчид хэнээс ч хамаат бус байж толгой даан үйлдвэрлэл явуулдаг болжээ. Энэ бол малаа өсгөж, ашиг шимийг нь бүрэн гүйцэт хүртэж, өөрөө эдэлж хэрэглэн, хэрэгцээнээс илүүг худалдан борлуулах, малын яс чанарыг сайжруулах, ашиг шимийг дээшлүүлэхэд юу хэрэгтэйг өөрснөө шийднэ гэсэн үг. Энэ хугацаанд малчдын ахуй амьдрал эрс сайжирч, тэд хувьдаа 100-500 толгой малтай, хадгаламжид мөнгөтэй, суух тохилог байшинтай, юм юмаар дутагдаж гачигдах зүйлгүй хангалуун сайхан амьдрах болжээ. Улсаас нэг төрлийн мал худалдаж авсан малчид өсгөж үржүүлсэн малынхаа зохих хэсгийг төлөвлөгөө ёсоор улсад худалдаж, заримыг нь мал малын захтай болох сонирхолын үүднээс бусад малаар солих буюу худалдах болжээ. Бараг бүх малчин мал малын захтай болж уналга эдэлгээ, хөсөг тээвэрт өргөн хэрэглэж байна. Дашрамд тэмдэглэхэд төрөөс хувийн аж ахуй эрхлэхийг зөвшөөрч хувийн аж ахуй нь зах зээлийг өргөжүүлэх, хүн амын хүнсний болон бусад олон талын хэрэгцээг хангахад үйлчилж социалист нийгмийн эдийн засаг, аж ахуйд туслах үр ашигтай нөхвөр мөн гэж шинэчлэн найруулсан үндсэн хуулинд заагаад түүнийг хууль эрхийн талаас хамгаалах, удирдан чиглүүлэх, туслан дэмжиж байхыг төрийн байгууллагуудад үүрэг болгожээ.¹⁶ Хувийн аж ахуй эрхлэхийг төрөөс дэмжсэний үр дүнд одоо Өвөр Монголын олонхи малчид улсад төлөх ёстой малынхаа үнийг төлж дуусаад малаа хувийн болгожээ. Ингэлээ гээд тэд улсад нийлүүлэх мал аж ахуйн бүтээгдэхүүнээ багасгасангүй, харин ч жил бүр нэмэгдүүлж ирэв. Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг худалдаж авах улсын үнэ өндөр учир малчид улсад худалдах их сонирхолтой ажээ. Бэлчээр, мал, малчин гурвын холбоосонд, малчин нийгэм хоёрын эрх ашгийн холбоонд завсрын шат болж үйлчилж байгаа хариуцлагын дүрмийн зарим гэм согог зөрчлийг арилгаж, улам боловсронгуй болгох үүднээс өөрчлөлтийн хоёр дахь шатны алхам болгож малчин нэг өрх байгаль цаг уурын хүнд нөхцөлд ядарч зовж байж үйлдвэрлэл явуулж байгаа өнөөгийн хүндрэлтэй хөдөлмөр зохион байгуулалтыг өөрчилж, малчин монголчуудын мал аж ахуйгаа эрхлэхдээ хэрэглэж ирсэн эртний уламжлалт хот айлын хэлбэрийг сэргээх, бэлчээрийг хамтарч ашиглах үүднээс ах дүү төрөл садан, цусан төрлийн холбоотой, ус нутгийн чиг нэгтэй 3—5 айлыг нэгтгэж мал аж ахуйгаа хамтран эрхлэх аж ахуйн бие даасан хэлбэрт орох нь аль аль талдаа ашигтайг амьдрал харууллаа гэж Өвөр Монголын судлаачид үзэж байна.¹⁷ Тэд үүнийгээ «холбоот цогц» гэж нэрлэжээ Мал аж ахуй эрхэлдэг аймаг, хошуу, сумдад үүнийг саяхнаас их дэмжиж байна. Өөрчлөлтийн хоёр дахь шатанд малчид урьдын адил малаа өсгөж үржүүлэх, бие даан зарж борлуулах эрх, хариуцлага хэвээр эдлэнэ. Гэхдээ нэгэнт дааж, авсан мал, мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгслийн үнийг төлж дууслаа гээд бусдад дамлан худалдах, түүнээс ашиг олох, шилжүүлэн өгөхийг зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэж болохгүйг тодотгож өгчээ.

Анх дааж авсан малын суурь тоог үндэслэн мал сүргээ өсгөх хэмжээг нэг удаа шинэчлэн тогтоосон бол түүнийг дараа жилийн өсөлт хорогдлыг тооцохгүйгээр 3 жилийн турш өөрчлөхгүйгээр тогтвортой мөрдөж байхаар болжээ. Гэрээний хугацааг ерөнхийдөө багасгаж 3 жилээр хязгаарлажээ. Малыг үнэлсэн мөнгөний 50 хувийг эхний жилд, 20 хувийг хоёрдахь жилд, үлдэх 30 хувийг гуравдахь жилд төлж дуусгахаар тогтоожээ.¹⁸

Өнөөгийн байдлаар Өвөр Монголын мал аж ахуйн салбарт улсын өмч, хувийн өмч, хоршооллын өмч, гадаад орнуудтай хамтарсан сангийн аж ахуйнуудад хамтын өмч, өрх гэрийн өмч зэрэг өмчийн харилцааны янз бүрийн хэлбэр үйлчилж байна.

Тэдэнд улсаас дэмжлэг үзүүлж үйл ажиллагааг нь аль аль талдаа ашигтай байдлаар зохицуулж байгаа нь зохих үр дүнгээ өгч байна.

Хөдөө аж ахуйн нийгмийн бүтэц, үйлдвэрлэлийн харилцаанд гарсан өөрчлөлтийг мал аж ахуйн салбараар жишээ болгон товчхон өгүүлэхэд ийм байна.

Улсаас хөдөө аж ахуйн нийгмийн бүтцийг өөрчилж, үйлдвэрлэлийн бие даасан байдлыг хангаж, таваар-мөнгөний харилцаа үнийн болон зах зээлийн механизмыг өргөн ашиглах асуудалд ихээхэн анхаарч ирсэн нь Өвөр Монголын хөдөө аж ахуйн нийгэм-эдийн засгийн хөгжилд мэдэгдэхүйц ахиц өөрчлөлт гаргаж чадсан байна гэж үзэж болохоор байна. Дашрамд тэмдэглэхэд сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн салбарт манай улс Өвөр Монголтой хамтран ажиллах эх суурь тавигдаж аймгуудын хооронд шууд харилцаа тогтож, хилийн худалдаа өргөжиж байна. Өвөр Монголд БНМАУ-ын мал аж ахуйн талаар гарсан судалгааны бүтээлийг орчуулан нийтлэх, энэ чиглэлээр судалгаа хийх эрдэмтэд олширч, зохиол, бүтээл туурвиж байна.

БНМАУ, ӨМӨЗО-д бэлчээрийн мал аж ахуйг эрхэлж ирсэн түүхэн уламжлал нь нийтлэг, байгаль цаг уур нь ижил төстэй учир түүнийг эрчимжүүлэн хөгжүүлэхэд үр өгөөжтэй арга туршлагаа харилцан солилцож, хамтран ажиллаж, харилцаагаа өргөтгөх явдал чухал ач холбогдолтой юм.

1. Өвөр Монголын өдрийн сонин. 1989. 04.22 И. Баатар, Бэлчээрийн мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх арга замын асуудалд (нийгмийн шинжлэх ухааны холбоот хурлын эрдэм шинжилгээний сэтгүүл, 1988, No 4, 39 дахь тал)
2. Хятадын Өвөр Монгол, Хөх хот, 1987, 55 дахь тал
3. М. Хасбагана. Мал аж ахуйн хамааралт. Шилийн гол 1988. 161 дахь тал
4. И. Баатар, Бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжүүлэх арга замын асуудалд - (Нийгмийн шинжлэх ухааны холбоот хурлын эрдэм шинжилгээний сэтгүүл. 1988., №4 3—35 дахь тал)
5. «Өвөр Монголын ардын өдрийн сонин» 1989. 04. 22
6. «Өвөр Монголын ардын өдрийн сонин» 1989. 04. 22
7. Хятадын Өвөр Монгол, Хөх хот., 1987, 39 дахь тал
8. «Эдийн засгийн боловсрол» 1989, No 11, 31 дахь тал
9. «Өвөр Монголын ардын өдрийн сонин» 1989 04 22
10. М. Хасбагана. Мал аж ахуйн хамааралт. Шилийн гол. 1988. 158 дахь тал
11. Мөн тэнд 159 дахь тал
12. Бүлгэмдэн байгуулж байгаа Өвөр Монгол (1947—1987) Хөх хот., 1987. 123 дахь тал
13. «Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан» 1983, N 2, 48 дахь тал
14. И. Баатар. Бэлчээрийн мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх арга замын асуудалд (Нийгмийн шинжлэх ухааны холбоот хурлын эрдэм шинжилгээний сэтгүүл, 1988, No 4, 34-35 дахь тал)
15. Өвөр Монголын ардын өдрийн сонин 1989. 04. 22
16. БНХАУ-ын үндсэн хууль, Бээжин. 1983, 17 дахь тал (орос хэлээр)
17. Орчлон. Манай орны мал аж ахуйн үйлдвэрлэлийн эзэгнэлтийн хэлбэрийн тухай сүвэгчлэх нь (Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, 1988. No 4, 26-27 дахь тал)
18. «Өвөр Монголын мал аж ахуй» 1989, No 2, 8 дахь тал